

Сайн сургуулийн ЗАСАГЛАЛЫН ОРЧИН-Ы шалгуур, үзүүлэлт

Шалгуур	Нөхцөл
Алсын хараа, бодлого журам, өндөр түвшний стандарттай	<p>Сургууль нь:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> оролцогч талуудын хамтран боловсруулж, баталсан эрхэм зорилго, алсын хараатай ба хүн бүр ойлгож, мэддэг <input type="checkbox"/> сургуулийн хамт олны хамтран боловсруулсан бодлого, дүрэм, журмаа бичгээр гаргаж мөрддөг <input type="checkbox"/> удирдлага нь сургуулийн аливаа шийдвэр, ялангуяа өөрсөдтэй нь холбоотой шийдвэр гаргахдаа талуудын оролцоог хангадаг, дэмждэг <input type="checkbox"/> мэргэжлийн болон ёс зүйн өндөр стандарт тогтоож, хүн бүрийг хүндэтгэдэг <input type="checkbox"/> багш, суралцагч, ажилтнуудын гаргасан ахиц дэвшлийг шударгаар үнэлдэг, энэ талаар дүрэм журамтай <input type="checkbox"/> хүн бүр тэднээс юуг, ямар байхыг, яагаад хүсэн хүлээж байгааг ойлгодог
Холбогдох бүх талын оролцоо хамтын ажиллагаатай	<p>Хүүхдийн оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> хүүхэд бүрийн дуу хоолойг сонсдог ба тэд шийдвэр гаргахад оролцдог <input type="checkbox"/> хүүхдийн өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагатай <input type="checkbox"/> сургуулийн зөвлөлд төлөөллөө сурагчид сонгодог <input type="checkbox"/> сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлдэг сувагтай ба хүүхэд бүрийн санал тусгагдан хэрэгжинэ гэсэн итгэлтэй <p>Багш, ажилчдын оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> сургуулийн аливаа шийдвэрийг, ялангуяа өөрсөдтэй нь холбоотой шийдвэр гаргахад оролцдог, саналаа хэлдэг <input type="checkbox"/> өөрсдийн санаачилгаар мэргэжлийн, ёс зүйн, ур чадварын болон хөдөлмөрийн зэрэг асуудлаар эвлэлдэн нэгддэг бөгөөд сургуулийн удирдлага хүлээн зөвшөөрч, дэмждэг <input type="checkbox"/> удирдлага нь багш нарыг мэргэжлээ дээшлүүлэхийг бүх талаар дэмждэг, боломж олгодог <input type="checkbox"/> сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлдэг сувагтай ба тэдний санал тусгагдан, хэрэгжинэ гэсэн итгэлтэй <p>Эцэг, эхчүүдийн оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> сургууль шаардлагатай мэдээллүүдийг тогтмол хүргэдэг <input type="checkbox"/> эцэг эхчүүд мэргэжлийн туслалцаа дэмжлэг авдаг <input type="checkbox"/> эцэг эхчүүдэд чиглэсэн арга хэмжээнүүд тогтмол зохиогддог <input type="checkbox"/> өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагатай, тогтмол үйл ажиллагаа явуулдаг <input type="checkbox"/> сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлдэг сувагтай ба тэдний санал тусгагдан хэрэгжинэ гэсэн итгэлтэй <p>Бусад талуудын оролцоо:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> иргэний нийгмийн байгууллагууд <input type="checkbox"/> хувийн хэвшил, олон улсын байгууллагууд <input type="checkbox"/> бусад талуудтай нээлттэй, идэвхтэй хамтран ажилладаг
Сургуулийн бүхий л үйл ажиллагаа ил тод, нээлттэй ба үнэлгээ, хяналт, хариуцлагатай	<p>Сургуулийн удирдлага нь:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> сургууль яаж ажиллаж байгааг оролцогч талуудад тайлбарлах, батлах чин хүсэлтэй <input type="checkbox"/> сургуулийн зөвлөл зохих ёсоор байгуулагдсан, бүхий л талуудтай зөвшилцөн хамтран ажилладаг, үйл ажиллагааны тайланг тогтмол танилцуулдаг <input type="checkbox"/> удирдлагын баг нь чадвартай, бие биенээ дэмжиж ажилладаг, харилцааны өндөр соёлтой <input type="checkbox"/> Багш, ажилтны амьжилтыг шударгаар үнэлж, урамшуулдаг, сургалтын чанар ахицыг байнга тооцож ажилладаг <input type="checkbox"/> Төсвийн ашиглалт, зарцуулалт ил тод, нээлттэй <input type="checkbox"/> Хариуцлагын тодорхой тогтолцоотой ба энэ талаар мэдээлэл ил тод, хариуцлагатай <input type="checkbox"/> Гарсан зөрчил, ирсэн санал шүүмжлэл, хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэх механизмтай ба ийнхүү шийдэхдээ хүний эрх, шударга ёсыг эрхэмлэдэг